

МАНХИЛАГ
Алтангэрэлийн ГҮРБЯМБАА

ЧУНГУСЧУН ТУГУУН СҮМ



Улаанбаатар хот
2008 он

ОРШИЛ

Эзэн Чингисийн үндэслэсэн Их Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жил, Чингисийн Тугийн сүмийн 140 жилийн ойг тохиолдуулан, Чингисийн дурсгалд зориулан 1866 онд тэр үеийн Саруул гүний хошуу, одоогийн Дорнод аймгийн Булган сумын нутаг БАЯН-ЭРХТ-д байгуулсан “ТУГИЙН СҮМ” буюу доктор Б.Ринчиний тодорхойлсноор “ЧИНГИСИЙН ШҮТЭЭНИЙ СҮМ” 1930-аад оны их хэлмэгдлийн үед бүрэн устгагдсаныг одоогийн үед түүх, соёл, эзэн Чингисийнхээ нэр алдрыг сэргээн мандуулж байгаа боломжийг ашиглан, орчин үетэйгээ зохицуулан өргөтгөх, сэргээн босгоход санаа өгөх зорилгоор энэхүү товхимлыг бичив.

Тугийн сүм дээр байсан ХАР ТУГ нь Хамаг Монголын үед XI-XII зуунд үүсэж, Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцовын хэлснээр “Чингис хааны сүнс нь тут сүлдэндээ оршиж байх болохоор ...чухамдаа нийт монголчуудад харъяалагдах монгол хүний сахиусан болно” гэсэнчлэн Чингис өөрөө шүтэж байгаад, дараа нь сүнс нь оршсон ХАРАА ИХТ ХАР СҮЛД-ийн ЭЛЧ сүлд болохыг түүхийн үүднээс нь тайлбарлахыг оролдов. Түүнчлэн Тугийн сүмийн үүсэл байдал, мөхлийг тайлбарлан бичив.

Зохиогч

ТУГ СҮЛДНИЙ УЧИР

Дэлхийн улс гүрэн бүхэн өөрийн улсын онцлог, хүндэтгэл, сүр хүчээ илэрхийлсэн туг сүлдтэй байдгийн нэгэн адил монгол туургатан ч туг, сүлдний онцлог түүхтэй билээ.

Монгол нутагт 2000 жилийн тэртээ анхны төр улсыг байгуулсан Хүннү гүрэн нар, сар, буга гөрөөсний дүртэй туг, сүлд хэрэглэж байсан бөгөөд энэ нь уламжлагдсаар XIII зууны үед Монголын нэгдсэн гулгар төр мандах хүртэл хэрэглэгджээ. XIII зуунд нэгдсэн Монгол Улсын үед их, бага есөн цагаан сүлд, Их цэргийн Их хар туг сүлд, дагуул туг сүлдүүдийг бүтээн хэрэглэж байжээ.

Нэгдүгээр бүлэг. СҮНС СҮЛДНИЙ УЧИР

СҮЛД гэдэг үгийг монгол толь бичигт зүлдээ, зүлд, зүлдү, сүлд гэхчлэн бичдэг. Монголчуудын амьдралын гол үндэс нь мал учраас малын амин гол эрхтнээр жишиж сүлдийг нэрэлжээ.

ЗҮЛДЭЭ гэдэг нь муулсан малынхаа толгойг багалзуур, уушиг, зүрхтэй нь залгалдуулан авсан хэсгийг хэлдэг байна. Энэ нь малын яг амин гол нь болохоор СҮНС орших орон гэж монголчууд машинд эрхэмлэн хүндэтгэж, Ордос дахь хараа ихт хар сүлдийг ийм зүлдээгээр гайж тахидаг монгол ёс заншлыг тэр чигээр нь өвлөн хадгалсаар ирсэн дархадууд хэл яриандаа “сүт”, “сүнс”, “сүлд сүнс”, “сүнс сүлд”, “сүлд хийморь”, “цог сүлд”, “сүр сүлд” гэх мэтээр холбож ярьдаг байна.

Тэд амьдралаа зөв сонгож чадаагүй, завхай зайдан замь хүмүүсийг шүүмжлэн, “Эд мөнгө, эмс охидод хөтлөгдсөн цог жавхаагүй амьтан, хийморь сүлд нь хэвтчихсэн амьтан” гэж ярьдгаас үзэхэд Сүлд, Сүнс хоёр бол хэрэг дээрээ утга нэгтэй үгс юм байна.

Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов “Чингис хааны сүнс нь туг сүлдэндээ оршиж байх болохоор энэ нь тус овог төрөл ба тус овогтоо (чухамдаа нийт монголчуудын гэвэл таарна) харъяалагдах монгол сахиус болно” гэж их зөв дүгнэжээ.

Хараа ихт хар сүлд бол Чингис хаан өөрийн биеэр оролцон тайж тахидаг, дайчин шүтээн, ялгуутсан туг нь байжээ. Энэхүү сүлд шүтээнийг XIII зууны монголчуудын оюун сүнс, ур ухааныг мөнх тэнгэр өөд хандсан нэгэн үзүүр мэт нэгэн жолоогоо болгож (дуугарвал дуу нэг, дугтарвал

хүч нэг) чадсанаас тухайн үеийн монголчууд, хандсан зүгт хариуцаж (эсэргүүцэж) чадах дайсангүй, ялгуусан туг юугаа ямагт ялалтын үр бүтээлээр мялааж явдаг байсан билээ.

“Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” номын 1-р бүлэгт “Хар сүлдийг хамгаалан, тахиж шүтэгч дархадууд Хараа ихт хар сүлдийг мөнх тэнгэрийн элч буюу мөнх тэнгэрийн сүлд сүнс, Чингис хааны гэгээн сүнс болон нийт монголчуудын үндэсний сүлд сүнс гурвуулан гурамслан оршиж байгаа орон” хэмээн үздэг гэжээ.

Хараа ихт хар сүлд бол эзэн Чингис хаан өөрөө тахиж шүтэж байсан шүтээн учраас ард түмний дотор “Хаан эзнээ ч сөхрүүлж байсан Хараа ихт хар сүлд” гэж яригддаг. “Чингис хаан өөрийнхөө болон монгол түмнийхээ хувь заяаг хар сүлдэндээ даатгаж мөргөдөг, эцэг өвгөдийнхээ гэрээслэлийг биелүүлэхээ тангарагладаг байсныг хойч үеийн хаадууд бүгд дагаж хэрэгжүүлж байжээ...” гэж уг номын “Эсгий туургатны хараа ихт хар сүлд шүтээн” гэсэн гарчигтай хэсэгт бичсэн байна.

Чингис хааны хараа ихт хар сүлдний тухай энэ бүх тайлбарыг БНХАУ-ын Өвөр Монголын Их зуу аймгийн эзэн хорооны “ЭЗНИЙ НАЙМАН ЦАГААН ГЭР”-ийг үе улиран сахиж, шүтэж, хамгаалж, сурталчилж ирсэн, олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, Чингис хааныг судлах хурлын байнгын дэд эрхлэгч Хэрэйд овогтой Норовын Шаралдайн (1934 онд төрсөн) 1988-1989 онд бичиж 2001 онд Улаанбаатарт кирилл үсгээр хэвлүүлсэн “Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” номыг ашиглан, бичсэн болно.

Хоёрдугаар бүлэг. ХАРАА ИХТ ХАР СҮЛД

Хар өнгө ба тугийн тайлбар

Хар өнгө нь ямар нэгэн хольцгүй өнгө бөгөөд монголчууд төр түшдэг хүнээ “ТӨРИЙН ХАР ХҮН” гэж нэрлэдэг нь энэ ёсонд зөвхөн нэгэн сэтгэлээр үнэнч байхын илэрхийлэл болгож тус өнгийг хэрэглэжээ.

Хөхөлд зориулж, амьд азраганы хөхлөөс (дэлнээс) нэг тугийг авна. Үүнээс үндэслэн, ТУГ гэдэг нь нэг туг үс гэсэн утгатай гэж судлаачид тайлбарладаг байна.

Хар сүлдийн дээд үзүүр нь байлдаанд хэрэглэдэг жадны хэлбэртэй, нэг тохой шахам урт, хоёр талдаа иртэй, голоороо зузаан, дороо онгитой, төмөрлөг эд болно. Энэ нь нэгэн үзүүрт сэтгэлээр мөнх тэнгэр өөд зааж, ганцхан мөнх тэнгэрийг шүтнэ гэсэн утгатай. Онгийн дээр цагаан мөнгөөр хийсэн цангийн төдий дугуй хэлбэртэй, цар хэмээгч юм бий. Царын хөвөөг дагуулан, есөн ес наян нэгэн нүх цоолж, хөхлийг (хөхөл гэдэг нь азраганы дэлний урд үзүүрийн туг хялгас) тогтооно.

Сүлдний хөхлийг мянган хар /хээр/ азраганы хөхлөөр хийнэ. Азраганы хөхлийг сонгосны учрыг тайлбал: Азрага болбоос сүргийн эзэн бөгөөд сүргээ араатан амьтнаас хамгаалан тулалддаг, сүр хүчийг илэрхийлэгч гэдгийг монгол хүн бүр мэддэг билээ. Иймээс төрийн их сүлдийг мянган азраганы сүр хүчтэй зүйрлүүлж, азраганы хөхөл шиг сүрлэг агаад ариун дагшин байхыг бэлэгджээ. Азраганы хөхөл дэл нь тэнгэрийн хур, салхи, нар, сарны гэрлээс өөр юу ч хүрдэггүй онгон ариун зүйл юм.

Сүлдний шилбэ ба дээл

Сүлдний шилбийг Иш, Шилбэ гэж судлаачид олон янзаар нэрлэдэг байна.

Тэгвэл хар сүлдийг амьд амьтантай зүйрлүүлж шүтдэг учраас амьтны тулгуурыг шилбэ гэдэг тул ШИЛБЭ гэж нэрлэх нь зөв юм байна.

Шилбийг 13 тохой (5 м гаруй) өндөр шулуун хуш модоор хийнэ. “Шилбийг онгинд угсарсны дараа мөнгөн шоннуурга оруулж, түүнээ цагаан торгоор юмбүү шиг хавирган сар хэлбэртэй ороож бэхэлнэ” гэж уг номонд бичжээ. Хөхлөө байрлуулж, шилбээ оруулсны дараа шилбэний гадуур дээл өмсгөнө. Үүнд: 12 тохой шар торгон дээл оёж, мянган билгүүний хувьд мянган товч хаддаг байжээ. Хар сүлдийг амьд шүтээн болгосонтой холбогдуулж, торгон дээлийг Хубилай хааны үеэс хэрэглэсэн бололтой гэж уг номонд бичжээ.

Шилбийг хамгаалах нь

Сүлд нь байнга гадаа мөнх тэнгэртэй харгалдаж байдаг тул шилбийг нь бороо, цас, нар, салхинд гандаж муудахаас хамгаалах хэрэг

гардаг. Ар Монголд сүлдний шилбийг нарийн зүссэн сураар боож хийдэг баримт бий. Энэ нь жинхэнэ эртний хэлбэр юм.




*Монгол цэргийн Их хар сүлдийг 1992 оноос
эхлэн 2 жилд нэг удаа Төв аймгийн Алтанбулаг
сумын Өгөөмөр толгойд цэнгүүлэх болов.
Гэрэл зургийг Д.Цэрэннадмид*

Энэ ёсыг баримтлан, 1992 онд Монгол Улсын Бүх цэргийн хар сүлдийг бүтээхэд шилбийг оонын хүзүүний арьсыг элдэж, зүсэж, ороож монгол аргаар хийсэн, шар цавуугаар нааж бүтээсэн нь Ар Монголд хар сүлдний элч (хувилбар)-ийг орчин үед шинээр бүтээж болдгийг гэрчилж байна. Хар сүлдний тайлга нь Эзэнт гүрний төр улсын хамгийн хүндтэй, ариун зан үйл байжээ. Үүнийг алтан ургийнхан бус харц ардын дотроос хаанд үнэнч зүтгэж, хүчээ өгсөн баатруудын удмынхан хариуцдаг.

Сүлдний тайлга, тахилга нь хэдийгээр бөө мөргөлийн зан үйлд багтдаг боловч хийгдэх ёстой бүх зүйлийг хуульчлан тогтоосон байдаг тул хэн ч өөрчлөх эрхгүй юм.

Сүлдний тайллагыг хариуцсан хүмүүсээс өөр хүн гүйцэтгэх ёсгүй тул бөө хүнээр хийлгэдэггүй байна.

Сонгож авсан хүмүүсийг "ДАРХАД" гэж нэрлэн, "Зөвхөн энэ ажлыг эрхлэн гүйцэтгэсүгэй" гэсэн зарлиг гарч байжээ. Тэр анхны дархадыг залгамжлагчид одоо хүртэл үргэлжилж, 37-38 дахь үедээ энэ албандаа үнэнчээр зүтгэж яваа ажээ.



Ордосын Эзэн хороон дахь Чингисийн Онгоны нүүдэл. 1930 он

ДАРХАД нь сүлдний тахилгыг дангаараа хариуцахаар дархлагдсан хүмүүс гэсэн утгатай бололтой.

Яагаад Хараа ихт Хар сүлд гэв?

Хар сүлдийг гагцхүү цэрэг дайны хэрэгт зориулан бүтээсэн учир Хар сүлдийг байгаа бодит дүрээс нь гадна бас амьдчилан (амьд юм шиг) авч үздэг бөгөөд энэ амьжуулсан хийсвэр дүр нь алам очирт жад барин хилэгнэсэн, нүүрэндээ мянган нүд, зангидсан үстэй догшин дүр байдаг ажээ.

Хар сүлд энэ мянган нүдээрээ аливаа дайсныг алдал үгүй харж, даран сөнөөдөг гэж үзэж байсан учир эртнээс нааш ХАРАА ИХТ ХАР СҮЛД гэж нэрлэж байжээ.

Есүхэй баатар, Жамух нар ХАРАА ИХТ ХАР ТУГ-тай байсан бөгөөд дайн байлдаанд мордохын өмнө

Хараа ихт тугаа тахиж
Хар бухын арьсаар бүрсэн
Харгих дуут хэнгэргээ дэлдэж
Хатан болд жадаа барьж
Халх хуягт дээлээ өмсөж
Хатгах зэвт сумаа онилж
Хар хул морио унаж

Хамаг олон цэргээ дагуулж... аян дайнд мордлог байсныг Монголын Нууц Товчоонд дурьдсан байдаг.

Ингэж Хамаг Монголын хаадууд аян дайнд мордохдоо хар тугаа тахин догшруулж, баатар догшин сүлд болгодог байсны зарим жишээг дурьдвал: Чингис хаан 1206 онд Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулаад, хар сүлдийг залахдаа умард Хятадын Алтан улсад хүргэгдэн алагдсан Амбагай хааны сүнсээр амилуулан догшруулж, дайснаа дарах цэргийн догшин сүлд болгосон гэдэг.

Чингис хааныг тэнгэрт хальсаны дараа түүний сүнс сүлдийг энэхүү хар сүлдэнд урин залж, амилуулсан гэх бөгөөд ийм учраас монголчууд хар сүлдийг “Богд эзэн Чингис хааны шүтсэн алтан сүлд” гэж ихэд хүндэтгэн, тахиж шүтсээр иржээ.

Хараа ихт хар сүлд нь суурин байнга гадаа хүндэтгэлтэйгээр байрлуулсан байх ба хар сүлдийн хувилбар буюу элч сүлд нь дайн байлдааны талбар болон гай гамшгийг зайлуулах зэрэг шаардлагатай газруудад хөлөг баатруудтайгаа явуулын явдаг байжээ.

Хар сүлд эх нутагтаа байсан тухай Монголын Нууц Товчооны 12-р бүлэгт дурьджээ.

Чингис хаан алс газар нас бараад, шарилыг нь нутгийн зүг авч гарах үед Сөнидийн Гилүгэтэй баатар:

“...Ураг элгэн монгол чинь

Улс олон иргэд чинь

Унасан Дэлиүн Болдаг чинь

Тэнд хол байна.

Хээр азраганы хөхлөөр хийсэн

Хиур туг сүлд чинь

Хэрлэнгийн хөдөө арал чинь

Тэнд бөлгөө эзэн минь... гэсэн нь хар сүлд туг нь эх нутагтаа байдгийг батлан харуулж байна.

“Хараа ихт хар сүлд нь үе залгамжилсан хамгаалагч дархадуудын ач гавъяагаар одоо ч Эзэн хорооноос зүүн урагш 50 бээрийн газарт байдаг” гэж буриадын эрдэмтэн Жамсрано бичсэн бөгөөд цааш тайлбарлахдаа Эзэн хороо нь түрүү зууны 70-аад оны сүүлчээр (19-р зуун бололтой) дээрэмдэгдэхэд хар сүлдийн хамгаалагч дархадууд тэмцэлдэн, дөрвөн хүнээ алуулж, их хэмжээний зүйлээ алдсан боловч зарим зүйлийг нь шүтээнийг хамгаалж байгаа дархадуудад буцааж өгчээ.

Хамгийн харамсалтай нь дээрэмчид авдарт байсан их хэмжээний гар бичмэл, судар номыг шатаажээ гэж академич, доктор Бямбын Ринчин дурдсан байдаг.

Эзэн Чингис хаан Хар сүлднээс гадна Цагаан сүлдтэй байжээ.

Чингис хааны Цагаан сүлдний тухай товчхон

Их эрдэмтэн Бямбын Ринчин "...Зүүн Монголд Чингис хааны дурсгалд зориулсан хоёр сүм байсан. Үүний нэг нь Монголын баруун хэсэгт орших тэр үеийн Лу гүний хошуунд, нөгөө нэг нь Монголын зүүн хэсэгт байжээ. Лу гүний хошуунд байсан сүмийг Чингис хааны цагаан сүлдэнд зориулж босгосон гэж дурдсан байдаг.

Чингисийн алтан ургийн сүүлчийн хаан Лигдэн тэнгэрт хальж, Монгол улс хаангүй болоход Чингис хааны Цагаан туг Ордос дахь Чингисийн онгонд хадгалагдаж байгаад, Ар Монгол Богд хаантай болсон тул 1915 оны намар цагаан тугийг Монголд, Эрдэнэзуугийн өмнөх Баруун хүрээнд авч ирсэн ажээ.

Цагаан сүлд хааны ордны гадаа залагдаж байвал энх амгалан байгаагийн тэмдэг болж байжээ.

Дөрвөн хөлт Хар сүлд

Гол сүлдийг бэхлэхийн тулд ард нь нэг шилбэ нэмж бэхлээд, гол сүлдийг чулуугаар зассан том мэлхийн нуруунд ... зэрэгцүүлэн нүхэлсэн хоёр нүхэнд гол ба ар шилбийг угсруулан тавьдаг. /"Онгон шүтээний тайлга тахилга" номын 21-р хуудсанд/

Дөрвөн элч сүлдийг чулуун суудал дунд нь малтсан нүхэнд хатгаж, гол сүлдтэй нь дөрвөн талаас нь чагталж, холбон бэхлэнэ.

Дөрвөн элч сүлд гэгч нь гол сүлдээ бэхэлсэн дөрвөн хөл нь юм. Иймээс дөрвөн хөлт сүлд гэдэг боловч үнэндээ ар шилбэтэйгээ бол таван хөлт ажээ. Дөрвөн тийш нь чагталж, холбох дээсийг азраганы дэлээр 13 алд томж, шар торгоор гадарладаг байжээ.

Хар сүлдний элч сүлд буюу хувилбар

Хараа ихт Хар сүлд бол Өвөр Монголын Ордост хадгалагдаж байгаад, 1939 оноос дайн самууны хөлөөс дайжин Чингис хааны онгон шүтээний хамт Ганьсу, Шаньси мужууд, Янь-ань хот, Шин Лун Шань уулын сүм, Гүмбэнээр байрлаж яваад, 1954 оны 4 дүгээр сарын 7-нд их Эзэн хороондоо эргэж иржээ.



Өвөр Монголын Ордос дахь Чингисийн онгон

Энэ талаар "Онгон шүтээний тайлга, тахилга" номонд "...Баруун гийш нүүлгэж явсан шүтээнүүд бол Чингис хааны болон Бөртэ, Хулан хатнуудын хуурцаг /эд агуурс, алт мөнгөний хайрцаг/, Хараа ихт хар сүлд зэрэг болно" гэж бичсэн байна. Нөгөө талаар тус номонд Б.Ринчиний бичсэнээс ишлэн "...Хар сүлд нь Эзэн хорооноос зүүн урагш 50 бээрийн газарт байдаг" гэжээ.

Эдгээрээс үзэхэд жинхэнэ (анхны) Хар сүлд нь Ордост Эзэн хороондоо байдаг тул бусад газруудад байгаа хар сүлд нь ЭЛЧ буюу ХУВИЛБАР, жинхэнэ хар сүлдний төлөөлөгч болох нь батлагдаж байна.



Хангин сүлд

Хангин хошууны ван ноён Алтан-очир Японыг дагаж, Бугат хотод сууж байжээ. 1939 онд Чингис хааны онгон шүтээн болон Хараа ихт Хар сүлдийг баруун тийш Ганьсу мужид шилжүүлэхэд "Одоо бид юунд мөргөх билээ?" гэж дархад Арвинбаярыг баруун тийш (араас нь) явуулахад нэгэн элч сүлдийг залуулжээ. Ингээд 1940 оны 3 дугаар сарын 21-ний цагаан сүргийн их тайлгын өмнө Чингисийн цомцог, ордон зэргийг бүрэн залах хөрөнгө мөнгийг Алтан-очир вангийн сан ба тэр үеийн тэргүүн ноёны засгийн газар хариуцжээ.

Цомцогны янз маяг нь эзэн хороон дахь Цомцог ордныг дууриан хийж, доторхи тайлгын сав хэрэглэлийг ч чадах хирээр дууриалган засаж бүрдүүлжээ.

Ингэж шүтэж тахисаар 1955 онд Чингисийн онгон шинээр байгуулагдахад их санд нийлүүлжээ.


**Гуравдугаар бүлэг. АР МОНГОЛ ДАХЬ
“ЧИНГИСИЙН ШҮТЭЭНИЙ СҮМ” буюу
“ТУГИЙН СҮМ”**

Тугийн сүмийн талаар сурвалжилсан минь

Түүх сонирхогчийн хувьд аймаг, сумандаа байсан эзэн Чингисийн нэртэй “Тугийн сүм”-ийн талаар олон домог яриа сонссон бөгөөд “Тугийн сүм”-ийн хавиар амьдарч, сүмээр орж, гарч байсан, хуучин Саруулын хошууны 70-80-аад настай өвгөчүүд Шагдарын Намхай, Дэмбэрэлийн Дашзэвэг, Мятавын Гэндэн, Бизъяагийн Балдан, Борын Жигжид, Мөрийн Дамбаравжаа, Гомбын Содов нартай 1980-аад онд уулзаж, яриулахад тэд нүдээр үзсэн ба сонссоноо хүүрнэж өгсөн билээ.

Тэд ярихдаа, Ачитын хошууны ноён Цэрэндоржийн Минжүүрдорж /1806-1866/, Саруулын хошууны ноён Жамсранжавын Дарамжав /1825-1869/ нарын үед Саруулын хошууны Баян-Эрхт хавийн ардууд мал хунаргүй шахам болж, маш ядуурч, амьдрахын аргагүй боллоо, харж үзээч гэсэн хүсэлт өргөдөл Сэцэн хан аймгийн Хэрлэнбарс хотын Чуулганы газарт ирүүлсээр байсан тул хоёр түшмэл явуулж, газар дээр нь үзэхэд, тэр хавийн айлуудын ихэнх нь уранхай, цоорхой бүрээстэй умгар хар гэрүүдтэй, гаднаа 5-10 хонь, ямаатай, ганц хоёр үнээ, унааны ганц, хоёр мориноос өөр юмгүй, үнэхээр ядуурсныг чуулган даргад илтгэжээ.

Чуулган дарга, алдарт Чин ван Тогтохтөр (То ван) төрөлхийн ухаалаг хүн байсан тул ард түмний зан заншил, шүтлэг бишрэлийг түшиглэн, урьд нь Халхын голын эрэгт Жанрайсаг бурхан бүтээж, олон газар сүм хийд, өөрийн хошуундаа /Илдэн Жонон вангийн хошуу/ цэцэрлэг, сургууль байгуулан, эдийн засгийн элдэв аргаар ард түмнийхээ амьдралыг дээшлүүлж байсан туршлагадаа үндэслэн, Баян-Эрхт хавийн ядуучуудын амьдралд туслах арга сэдэжээ.



Туг уул. Зураач Г.Доржгочоо

Хамаг Монголын үеэс уламжлалтай Хараа ихт хар туг нь дайн байлдаан болон гай гамшиг зэргийг зайлуулан дарах зорилгоор тахилга догшруулалт үйлддэг байсныг мэддэг байсан нь гарцаагүй. Үүнээс санаа авч, ядуурлын гай гамшигаас ард түмнээ аврахын тулд Баян-Эрхтэд эзэн Чингисийн Хар сүлдний элч сүлд буюу хувилбарыг залах Чингисийн шүтээний сүм байгуулж, түүний жас хөрөнгийг түшиглүүлэн, тэр хавийн ялдуучуудыг ажил амьдралтай болгохоор Баян-Эрхт дээр эзэн Чингисийн Хар сүлд бүхий сүм байгуулна хэмээн Минбэйсийн хошуу, Саруул гүний хошуу даяар зарлаж, хандив өргөхийг хүсчээ.

Ингэж эзэн Чингисийн сүнс сүлд болон монгол түмнийг даян дэлхийд цуурайтуулсан энэ нэр төртэй, хар сүлдийн элчийг өөрийн нутагтаа залах аз завшаан тохиолдсонд бэлэгшээсэн тус хошууны ядуу буурай ардаас эхлэн, баячууд, ноёд түшмэд хүртэл бүхий л бололцоогоо дайчлан, хандив өргөж, богино хугацаанд асар олон мал, хөрөнгө цугларчээ.

Тугийн сүмийн жасад хандиваар цугларсан олон суурь хонь, адуу, үхрийг маллах, ахлах, туслах малчид, малын үс ноос авч, сур дээс бэлтгэх, арьс элдэх, сүү цагаа боловсруулах, малчдын гэр тэрэг бэлтгэх дархчууд, сүмд суух хориод ламд үйлчлэх гээд олон тооны ядуучууд ажил амьдралтай болж, одоогийн хэлээр бол олон хүний ажлын байр бий болгосон юм гэнэ лээ гэж өвгөчүүд ярьж билээ.

Тугийн сүмийн гаднах зохион байгуулалт

Өвгөдийн ярьсаны дагуу би өөрөө Баян-Эрхт дээр очиж, сүмийн бусад хашаа барилгын туурь, суурийн бүдэг ормыг хэмжиж, сүмийн ганц бүтэн хөх тоосгыг ч авч билээ. Баян-Эрхт нь эртний түүхт Бар хотоос зүүн урд зүгт, Хэрлэн голын урд дээр, тэр хавьдаа өндөрлөг, шовх толгой байна.

Түүний орой дээр гол давхар сүм нь байсан бөгөөд энэ нь хүндэтгэл ёслолын чанартай, нэр хүнд, гоёмсоороо нэрд гарсан болохоос биш хэмжээ жижигхэн, ердөө 8х12 метрийн орчим харьцаатай талбайтай, түүний зүүн талд нэг жижиг байшин юм уу, сүм байсан бололтой туурь бий. Гол сүмээс урагш 6х8 метрийн нэгэн суурь байна. Түүнээс урагш 4х8 метрийн жижиг байшин юм уу, бас нэг сүмийн ор бий.



Тугийн сүмийг 1938 онд сүйтгэхээс нь өмнөхөн энэ зургийг Булган сумын харъяат, сүүлд НАХЯ-ны архивын эрхлэгч болсон Дугарын Дагвасамбуу авчээ. Энэ бол Тугийн сүмийн цор ганц зураг юм.

Түүнээс урагш Баян-Эрхтийн толгойн урд энгэрт шахам 12х18 метрийн том сүм юм уу, хашааны суурь бий. Энэ бол 16 лам ба гэсгүй унзад зэрэг 20-иод лам байнга сууж, хурал хурдаг Хөх сүм гэдгийнх нь суурь бололтой. Түүнээс зүүн урагш 40-өөд метрт 20х30 метрийн орчим хэмжээний суурь байсан нь настнуудын хэлдгээр хогийн хонхор гэдэг нь бололтой. Тугийн сүмийг 27 см урт, 13 см өргөн, 5 см зузаан хөх тоосгоор барьсан байлаа. Харин энэ тоосгыг гаднаас авчирсан уу, эндээ хийсэн үү гэдгийг мэдэх баримт олдоогүй бөгөөд настнуудын ярьснаар сүмийн зүүн хойно тоосго хийдэг бааюуны газар байсан гэдэг.

Тугийн сүмийн ар талыг налаад, Баян-Эрхтийн овоо, түүнээс хойш 25 метр орчимд лам нарын овоо гэж байжээ.

Ахмад настан Бизъяагийн Балдан ярихдаа, Сүмийн ар талд, дээрээ алтан ганжир /дог/-тай дороо гурван тулгууртай, маш өндөр мод байдаг. Үүнийг чийга ямнай гэдэг. Энэ нь эзэн хаанд мэдэлтэй /хааны мэдлийн/ сүмд байдаг гэлцдэг гэсэн билээ.

“Чингисийн онгон шүтээний тайлга, тахилга” номонд Хараа ихт хар сүлд /туг/ нь ямагт харуул хамгаалалттай, орон нутагтаа хөдөлгөөнгүй суурин байж, хаан эзнийхээ ажил үйлс, монгол түмнийхээ хувь заяаг хариуцаж байдаг.

Харин элч сүлд бол дайны талбарт хөлөг баатруудтайгаа явж, Хараа ихт хар сүлдтэйгээ мөнх тэнгэрээр холбогддог байсан учраас хар сүлдийг байнга гадаа байлгадаг байжээ. “Элч сүлд” гэдэг нь хар сүлдийн элч төлөөлөгч гэсэн утгатай ажээ.

Манай Тугийн сүмийн гадна байдаг байсан Хар туг нь Хараа ихт хар сүлдийн элч төлөөлөгч байжээ. Мөн нутгийн ахмад настан Борын Жигжид ярихдаа “Тугийн сүмийн гадна байдаг боодолтой тугийн дээд талд дугуйрсан хялгасан цацагтай байсан” гэсэн нь “...тайлга, тахилга” номонд сүлдний шилбийн /иш/ орой дахь царын хөвөөг дагуулан, есөн ес наян нэгэн нүх цоолж, хөхөл /азраганы дэл/ тогтоосон байна” гэсэнтэй таарч байна.

Тугийн сүмийн дотоод байдал

Энэхүү сүмд Чингис хаан хийгээд түүний их хатан, есөн өрлөг, жич Чингис хааны байлдан дагуулсан улс гүрний ахлагч нарын дүрийг бүтээн байрлуулсан байжээ. Тэнд үнэт олдворууд болох эртний гар бичмэл, нум сум, хуяг дуулга, илд бамбай, туг дарцаг зэрэг олон тооны зүйлүүд хадгалагдаж байсан байна. Энэ тухай Тугийн сүмээр орж гарч байсан нутгийн ахмадууд Бизъяагийн Балдан, Шагдарын Намхай, Дэмбэрэлийн Дашзэвэг, Борын Жигжид, Мөрийн Дамбаравжаа, Гомбын Содов нарын дурьтгалд “Тугийн хоёр сүм байсан. Баян-Эрхтийн урд энгэрт нь хөх тоосгон сүм байсан, тэр сүмд дээрээс томилогдсон гэсгүй, унзад хоёроос гадна Саруул гүний хошуу, Ачит бэйсийн хошуу хоёроос тус бүр найман ламтай, их жас хөрөнгөтэй, тахилгатаа гурван настай морь уралдуулдаг том газар байсан юм” гэгцгээж байлаа.

Харин "Чингисийн онгон шүтээний тайлга, тахилга" номонд орсон эрдэмтэн Б.Ринчин гуайн өгүүлэлд "Сүмд ороход хоёр хатавчинд нь Орос, Хятад, Төвд, Өөлдийн дөрвөн хаан Чингис хаанд хандаж, смбүү, хуй торго барьж сөхөрсөн баримал байна. Сүмийн хойморт Чингис шар горгон дээлтэй сууж байгаа маш том баримал байх ба түүний өмнө нум, сум дээр нь дүүрэн хадаг тавьж, мөн нэг ном байсан, сүмийн хоёр талаар хуяг дуулга, илд бамбай зэрэг бүрэн зэвсэг, баатрын өмсгөлтэй есөн өрлөг, сүмийн голд нэг эмэгтэй хүн Чингист хандаж, гараа сунгасан баримал байдаг байлаа.

Баруун талын баатруудын эхний баатар нь барын дүрстэй бариультай төрийн тамга барьсан байсан. Тугийн сүмд орсон хүмүүс хүүхдээ гар дээрээ өргөж, баатруудын биед хүүхдийнхээ гарыг хүргэхэд баатруудын том алаг нүд зэргээс нь хүүхэд айж, уйлдаг байж билээ" гэжээ.

Мөн сүмд ороход үүдний хоёр талын баатар хуйтай сэлмээ шархийтэл хагас татдаг, хоёр талын есөн өрлөг баатруудын толгой хаалга руу хардаг төдийгүй, эзэн Чингист мөргөхөөр голоор нь явахад баатруудын толгой дагаж эргэдэг байсан гэх яриа одоо ч нутгийн ард түмний дунд яригдсаар байна.



Тугийн сүмд тогтмол сууж байсан 16 ламын сүүлчийнх нь болох Гомбын Чүлтэмбалжир /1906-1983/

"Сүмд ЧИНГИСИЙН ТӨЛӨГ гэж шившлэг ном байсан. Юм мэргэлэхдээ савхан хувинд /одоогийн хоёрын бетон шиг/ ноймертой олон тооны савх мод хийгээд шигшихэд нэг нь дээшээ гардаг, түүнийг номонд тааруулан, мэргэлдэг байсан" гэж өвгөчүүл бас дурсацгаасан юм.

Оросын их эрдэмтэн Жамсраны Цэвээн 1910 онд Чингис хааны "Цагаан сүлдний их тахилгад биеэр оролцсон тэмдэглэл" дотор "Орды шүтээнүүдийг байрлуулж, дуусмагц... хувь хүмүүсийн мөргөл эхэлнэ. Мөргөлчид мөргөлийн жагсаалтанд нэрээ бичүүлж, зохих хэмжээний мөнгө төлнө... мэргэ төлөг тавиулах эсэхээ хэлнэ, мэргэлүүлэх бол өргөл барьц өргөнө... мэргэн төлөгч дархад Чингисийн төлөгний айлдварыг тайлбарладаг байна.

Мэргэ төлөг тавиулах асуудлыг тусгай цаасан дээр бичиж, Чингисийн онгоны өмнөх ширээн дээр тавина. Үдэш нь дархад хүн / онгоныг хамгаалан сахигч/ ирж, хариуг нь өөр цаасан дээр бичээд, асуултын эзэнд гардуулан өгнө" гэж тэмдэглэжээ.

Энэ эрдэмтний бичсэн мэргэ төлөг, Тугийн сүмийн "Чингисийн төлөг" хоёр бас л уялдаатай байна. Үүнээс үзвэл манай ахмадуудын дурсамж үнэний үндэслэлтэй бололтой.

Тугийн сүм хэзээ үгүй болов?

Тугийн сүм 1930-аад онд монгол орныг хамарсан их хэлмэгдүүлэлтэнд өртөж, хоосрон, улмаар 1939 онд устгагджээ. Энэ үед Дорнод аймгийн Булган сумын Тугийн сүмийн хавь нутгийг хамарсан 8-р багийн дарга байсан Дэмбэрэлийн Дашзэвэг /Цагаандаш/ 1980-аад онд ярихдаа "Намайг багийн дарга байхад сумын дарга Базарын



Тугийн сүмийн дээвэр дээр залж байсан Хар сүлдний Элч сүлд эдүгээ Улаанбаатар хотноо Түүхийн төв музейн Чингисийн танхимд буй. Сүлдний цамцыг төмрөөр хийжээ.

Намсрайгаар дамжуулан, дээд байгууллагын шийдвэрээр Тугийн сүмийг буулгах болж, Туг хавийн залуучуудыг дайчлан, сүмийг буулгаж, дотор нь байсан Чингис хаан ба бусад барималуудыг гаргах болсон. Тэгээд хаалгаар нь багтахгүй байсан учир сүхээр цавчиж, хөрөөгөөр хөрөөдөж, жижиглэн гаргасан юм.

Харин энэ баримлууд харахад хүрэл, зэс мэт гялалзсан хүрэн юмнууд байсан боловч эвдээд үзэхэд дандаа цаас, даавуу нааж хийсэн байсан. Шалан доороос нь дан модон оньс гарсан тул эвдэхэд хялбар, өргөхөд хөнгөн байж билээ.

Ихэнх жижиг бурхан, голт цөгц бурханы жижиг хэрэглэлүүдийг Хогийн хонхорт булсан юм. Сүмийн гол материал, том бурхад, зарим ном судруудыг

62 тэмээн хөсгөнд ачиж, Баянтүмэн дахь Дотоод яамны хэлтсийн шар хашаанд буулгасан юм даа” хэмээн хуучилж билээ.

Сүмийг буулгаж, барималуудыг цавчиж, эвдэж гаргасан залуучуудаас Хоролын Шаравдаржаа, Сүхбаатарын Санжаа нар Халх голд дайнд очмогцоо дайсны бөмбөгөнд өртөж нас барахад сүсэгтэн олон зэвүүцэж, “Чингис хаан ба баатруудыг цавчиж, хэсэгчиж, бурхан тахилыг сүйтгэсний гай болсон байлгүй, бусдад нь гай тусах вий” гэж бурхан тэнгэртээ залбирч байжээ. Энэ бол сүсэгтний бодол болохоос биш тийм юм гэж хаа байхав гэж өвгөн тайлбарлаж байлаа.

Өвгөн цааш нь ярихдаа “Тугийн сүм жас мал ихтэй, баян байсан бөгөөд мал нь голдуу дээд Булганаар байдаг, хар цагаан голдуу адуутай, адуучнаар нь тарган хочит Цэвэг, Дүржил нар ажиллаж байдагсан. Тус сүм Гомбо бурхантай, хориод ламтай, сүмийн нярваар цоохор Дугар, Осор нар ажиллаж байлаа. Тугийн сүмийн сүүлчийн гэсгүй нь Гомбын Содовын /Хорхоодой/ ах лам байсан (нэрийг нь мартаад байна), сүүлчийн гэлэн нь Чосн гэлэн байсан шиг санаж байна.

Тугийн сүмийн бүтэн фото зургийг манай Саруулын хошууны уугуул, Нийгмийг аюулаас хамгаалах яамны архивын эрхлэгч байсан Дугарын Давагсамбуу авсан юм. Хотоор музей энэ тэрд байж мэднэ” гэж билээ.



Төв музейд буй Элч сүлдний охь.

боломж байгаа тухай болон БНХАУ-ын Өвөр Монголд Чингисийн онгоныг хэрхэн олон талаас нь дэмжин санхүүжүүлж, сэргээн босгосон туршлага зэргийг судлан, ЭЗЭН ЧИНГИСИЙН АЛТАН СҮЛД гэж нэршсэн Хар сүлдний элч сүлдийг байрлуулсан Тугийн сүмийг шинээр байгуулах нь зүйтэй юм.

Үнэхээр ч энэ фото зураг Улсын музейд байсан ба сүүлд аймгийн музейд хуулбар нь ирсэн байсныг миний бие 1989 онд “Туг нэгдлийн 30 жил” гэдэг номныхоо арын хавтсанд буулган үлдээсэн юм. Тугийн сүмийн талаар эдгээр эрдэмтдийн судалгаа дүгнэлтүүд, Тугийн сүмийг нүдээр үзэж, гараараа буулгасан хүмүүсийн дурьтгалууд, фото зураг зэргийг үндэслэн, Тугийн сүмийг хуучин хэлбэр тоноглолоор нь сэргээж, одоогийн шинэ нөхцөлд хэрхэн өргөжүүлэн, байгуулах

“ЧИНГИСИЙН ТУГИЙН СҮМ” номын

Ном зүй, ашигласан материалууд

1. Академич Ч.Далайн “Хамаг монголын хаад” ном
2000 он. 29-30-р хуудас
2. Академич Ч.Далайн “Хамаг монголын хаад” ном
2000 он. 35-р хуудас
3. Академич Ч.Далайн “Хамаг монголын хаад” ном
2000 он. 93-р хуудас
4. 1990 онд уйгар үсгээр хэвлэгдсэн “Монголын Нууц Товчоо”
III-р бүлэг, 106-р хуудас
5. “Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” ном
2001 он. 155-р хуудас
6. “Чингис хааны онгон шүтээний тайлга тахилга” ном
2001 он. 16-р хуудас
7. “Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” ном
2001 он, 226-р хуудас
8. “Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” ном
2001 он. 153-р хуудас
9. “Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга” ном
2001 он. 225,231,232-р хуудас

“ЧИНГИСИЙН ТУГИЙН СҮМ” номыг бичихэд

ашигласан бусад баримтууд

1. Тугийн сүмээр орж, гарч байсан Саруул гүний хошуу буюу одоогийн Дорнод аймгийн Булган сумын өндөр настнуудаас 1980-2002 онуудад уулзаж, лавлан яриулсан дурьдатгалууд,
2. Монголын нэрт эрдэмтэн Б.Ринчин, Ч.Далай, оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов, доктор Жамсрано Цэвээн нарын хэвлэл номуудад бичсэн материалууд,
3. Дорнод аймгийн музейгээс хуулбарлан авсан Тугийн сүмийн зурагчин Дугарын Давагсамбуугийн 1938 онд авсан фото зураг
4. “Олон Улсын Монгол Судлалын Холбоо”-ны гишүүн Өвөрмонголын Чингис хааныг судлах хурлын байнгын дэд эрхлэгч хэрэйд овогт Норовын Шаралдайн /“Чингис хааны онгон шүтээний тайлга тахилга” 2001 он/ номын зарим зургууд зэргийг ашиглав.

“ЧИНГИСИЙН ТУГИЙН СҮМ”

Зохиогч: А.Гүрбямбаа

Хянасан: Ж.Нэргүй

Эх бэлтгэл: Б.Тунгалаг

Хэвлэлийн хуудас: 1.25

Цаасны хэмжээ: 60/88/16

Хэвлэсэн тоо: 300ш

**Энэхүү номыг ҮШН-ыг үүсгэн байгуулагч,
М.Энхсайхан ивээн тэтгэж хэвлүүлэв.**

Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.